

## **БАНКНЫ БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Энэхүү журмыг Банкны тухай хуульд заасан үндэслэлээр бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах шаардлага үүссэн банкны системд нөлөө бүхий банканд хэрэгжүүлэх бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг боловсруулах, батлах, хэрэгжүүлэхэд баримтална.
- 1.2. Бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөний зорилт нь банкны бүтэц, үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг үндэслэн бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгарч болох хүндрэл бэрхшээл, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, шаардлагатай бэлтгэл ажлыг урьдчилан хангахад оршино.
- 1.3. Бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг банкны үйл ажиллагааны онцлог, банкны системд эзлэх байр суурь, санхүү, төлбөрийн чадварын нөхцөл байдал, харилцагчийн суурь, өөрийн хөрөнгө, хувь нийлүүлэгчдийн бүтцийг харгалзан, Банкны тухай хуульд заасан арга хэрэгслийг дангаар болон хослуулан хэрэглэх хувилбарыг тодорхойлж, боловсруулна.
- 1.4. Бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө нь Банкны тухай хууль, Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцтэй байна.

### **Хоёр. Бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх**

- 2.1. Банкны бүтцийн өөрчлөлт хариуцсан нэгж нь банкны системд нөлөө бүхий банканд шаардлагатай тохиолдолд хэрэгжүүлэх бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг жил бүр боловсруулна.
- 2.2. Банкны бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг боловсруулахад дараах мэдээллийг үндэслэл болгоно:
  - 2.2.1. Банкны санхүүгийн тайлан;
  - 2.2.2. “Банкны системд нөлөө бүхий банкиг тогтоох аргачлал”-д дурдсан банкны нөлөө бүхий байдлыг тогтооход ашигласан хүчин зүйл, үзүүлэлт;
  - 2.2.3. Банканд хийсэн хяналт шалгалтын дүгнэлт, материал;

- 2.2.4. Банкнаас ирүүлсэн тогтворжуулах төлөвлөгөө;
  - 2.2.5. Монголбанкнаас шаардсаны дагуу банкнаас ирүүлсэн нэмэлт баримт, материал, мэдээлэл;
  - 2.2.6. Бусад шаардлагатай мэдээлэл.
- 2.3. Бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөнд шаардагдах мэдээллийг бүрдүүлэх зорилгоор банканд газар дээрх хяналт шалгалтыг хийж болно.
- 2.4. Банкны тухай хуульд заасны дагуу банканд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах нөхцөл байдал үүссэн эсхүл үүсч болзошгүй нөхцөл байдал бий болсон тохиолдолд банкны хяналт шалгалт хариуцсан нэгж нь банкны бүтцийн өөрчлөлт хариуцсан нэгжид тухайн нөхцөл байдал үүссэн банктай холбоотой бүх мэдээллийг хүргүүлнэ.
- 2.5. Бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг дараах тохиолдолд тухай бүр шинэчлэн боловсруулна:
- 2.5.1. Энэ журмын 2.4-д заасан нөхцөл байдал үүссэн;
  - 2.5.2. Бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөнд тусгасан банкны санхүүгийн үзүүлэлт, банкны бүтэц зохион байгуулалт, банкны системд эсхүл банканд ач холбогдол бүхий үйл ажиллагаа, түүний үзүүлэлтэд материаллаг хэмжээний өөрчлөлт орсон;
  - 2.5.3. Шаардлагатай бусад тохиолдолд.
- 2.6. Бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг банканд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах тухай шийдвэрийн хавсралтаар батална

### **Гурав. Бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөний бүтэц, агуулга**

- 3.1. Бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө нь дараах бүтэц, агуулгатай байна:
- 3.1.1. **Агуулга:** Бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөний бүтцийг хураангуйлан тусгана.
  - 3.1.2. **Банкны мэдээлэл:** Банкны бүтэц зохион байгуулалт, санхүүгийн байдал, банкны болон банкны системд ач холбогдол бүхий үйл ажиллагаа, банкны нэгдлийн оролцогчийн мэдээллийг дараах байдлаар тусгана:
    - 3.1.2.1. Банкны хувь нийлүүлэгчдийн эзэмшлийн хувь, хэмжээ, бусад мэдээлэл;
    - 3.1.2.2. Банкны удирдлага, бүтэц зохион байгуулалт, салбар нэгж, хүний нөөцийн мэдээлэл;
    - 3.1.2.3. Банкны санхүү, төлбөрийн чадварын байдал;

- 3.1.2.4. Банкны системд ач холбогдол бүхий үйл ажиллагааны эзлэх хувь, хэмжээ, оролцоо;
  - 3.1.2.5. Банкны системд ач холбогдол бүхий санхүүгийн үйлчилгээний дэд бүтэц, мэдээллийн технологийн үйл ажиллагааны мэдээлэл;
  - 3.1.2.6. Банканд ач холбогдол бүхий үйл ажиллагааны мэдээлэл;
  - 3.1.2.7. Харилцан хамаарал;
  - 3.1.2.8. Шаардлагатай бусад мэдээлэл.
- 3.1.3. Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хувилбар:** Банкны мэдээлэл, тухайн банканд үүсэж болох төлбөрийн чадвар алдагдах, хэвийн үйл ажиллагаа алдагдах төсөөллийг үндэслэн бүтцийн өөрчлөлтийн арга хэрэгслийг дангаар болон хослуулан хэрэглэх хувилбарыг боловсруулна. Хувилбарыг боловсруулахдаа дараах хүчин зүйлсийг харгалзана. Үүнд:
- 3.1.3.1. Банкийг албадан татан буулгахад учрах хохирол, зардлын тооцоолол;
  - 3.1.3.2. Банкны алдагдлыг шингээх өөрийн хөрөнгийн чадвар;
  - 3.1.3.3. Банкны бүтээгдэхүүн үйлчилгээний харилцан хамаарал, алдагдал учруулж буй бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг салгах, тусгаарлах боломж;
  - 3.1.3.4. Бусад шаардлагатай хүчин зүйл.
- 3.1.4. Банкны үйл ажиллагааны тасралтгүй байдал:** Банканд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хувилбарыг хэрэгжүүлэх явцад тухайн банканд хийх үйл ажиллагааны болон санхүүгийн хязгаарлалт, түүний үргэлжлэх хугацааг тодорхойлно. Хязгаарлалтын хамрах хүрээг дараах төрлөөр ангилж болно. Үүнд:
- 3.1.4.1. Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээ;
  - 3.1.4.2. Банкны салбар, нэгжийн үйл ажиллагаа;
  - 3.1.4.3. Банкны эх үүсвэр, өр төлбөрийн үүргийг гүйцэтгэх хугацаа;
  - 3.1.4.4. Бусад.
- 3.1.5. Олон нийттэй харилцах, мэдээлэл солилцох:** Тусгай төлөөлөгч нь аливаа этгээдтэй (тухайн банкны хувь нийлүүлэгч, харилцагч, ажилтан, удирдлагын баг, банкны нэгдлийн оролцогч, бусад байгууллага г.м) харилцах, мэдээлэл солилцох үйл ажиллагаа, түүний цар хүрээг тодорхойлно.
- 3.1.6. Хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт:** Бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөний хувилбар тус бүрийн үнэлгээ, хэрэгжүүлэхэд тулгарч болох хүндрэл бэрхшээл,

тэдгээрийг шийдвэрлэх боломжит арга замыг дараах байдлаар тодорхойлно.  
Үүнд:

3.1.6.1.Банканд үзүүлэх нөлөө;

3.1.6.2.Банкны системд үзүүлэх нөлөө;

3.1.6.3.Банкны системд ач холбогдол бүхий үйл ажиллагааг цаашид хэвийн үргэлжлүүлэх боломж.

3.1.6.4.Бусад.

### **Дөрөв. Хяналт хариуцлага**

- 4.1.Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг Монголбанкнаас баталсан бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.
- 4.2.Монголбанкнаас баталсан бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд шинэчилсэн төлөвлөгөөг Банкны хяналт шалгалтын хороогоор хэлэлцүүлж, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар шинэчлэн батална.
- 4.3.Тусгай төлөөлөгч нь тухайн нөхцөл байдалд үндэслэн бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл энэ тухай санал, саналыг тусгасан шинэчилсэн төлөвлөгөөг боловсруулж, Монголбанканд хүргүүлнэ.
- 4.4.Энэ журмын 4.3-т заасан санал, шинэчилсэн бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг банкны бүтцийн өөрчлөлт хариуцсан нэгж нь хянаж, ажлын 5 хоногт багтаан энэ журмын 4.2-т заасны дагуу хэлэлцүүлж, шинэчлэн батална.
- 4.5.Бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг 2 хувь үйлдэж, нэг хувийг Тусгай төлөөлөгч, үлдэх хувийг Монголбанк хадгална.